

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Богдхан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгосугай.
2. Богдхан төмөр замын суурь бүтцийн технологийн иж бүрдэл болох инженерийн дэд бүтэц, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөгийн болон дохиолол холбоо, мэдээллийн барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, магадлал хийлгэх, тэдгээрийг барихад шаардлагатай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу тухай бүрд нь шуурхай олгож ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Зам, тээврийн хөгжлийн сайд Л.ХАЛТАР